

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн хууль тогтоомж

2.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар Монгол Улсад бүртгэлтэй ашгийн төлөө хуулийн этгээд Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсруу энэ хуульд заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Виртуал хөрөнгийн үйлчилгээнээс учирч болох эрсдэл, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний харилцагчийн хооронд хийгдсэн гэрээ, хэлцлээс үүсэх маргаан болон Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгө, бусад улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэрийг ашиглах, гүйлгээнд оруулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

3.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээнээс учирч болох эрсдэл, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний харилцагчийн хооронд хийгдсэн гэрээ, хэлцлээс үүсэх маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“виртуал хөрөнгө” гэж дигиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дигитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг;

4.1.2.”виртуал хөрөнгийн үйлчилгээ” гэж хүн, хуулийн этгээд, гэрээ хэлцэлд оролцогчийн нэрийн өмнөөс, тэдгээрийн захиалгаар, эсхүл тэдгээрт зориулан хийж байгаа виртуал хөрөнгийн дараах үйл ажиллагааг ойлгоно:

4.1.2.а.виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд нь арилжих;

4.1.2.б.нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих;

4.1.2.в.виртуал хөрөнгийг шилжүүлэх (бусдын нэрийн өмнөөс виртуал хөрөнгийг нэг виртуал хөрөнгийн хаягаас, эсхүл данснаас нөгөө рүү шилжүүлэх);

4.1.2.г.виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах. удирдах;

4.1.2.д.виртуал хөрөнгийг олон нийтэд санал болгох, худалдахтай холбоотой санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх.

4.1.3.“виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж энэ хуулийн 4.1.2-т заасан үйлчилгээний аль нэгийг, эсхүл хэд хэдийг үзүүлэхээр энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн Монгол Улсын ашгийн төлөө хуулийн этгээдийг;

4.1.4.”харилцагч” гэж виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс үйлчилгээ авч байгаа этгээдийг;

4.1.5.“холбогдох этгээд” гэж виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтан, хуулийн этгээдийн хувьцааны тав, түүнээс дээш хувийг эзэмшдэг хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн нэгдлийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

5 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага

5.1. Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээр бүртгүүлэх хүсэлт гаргасан Монгол Улсын ашгийн төлөө хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1. тухайн хуулийн этгээдийн үзүүлэх үйлчилгээ нь энэ хуулийн 4.1.2-т заасан виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарсан байх;

5.1.2. олон улсад нийтлэг ашиглагддаг бөгөөд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хүлээн зөвшөөрсөн технологийг ашигладаг байх;

5.1.3. хүсэлт гаргагч болон хүсэлтэд дурдсан үйл ажиллагаатай холбогдох бусад этгээдийн мэдээлэл тодорхой байх;

5.1.4. тухайн үйл ажиллагааг явуулах бүтэц, зохион байгуулалт, мэргэшсэн хүний нөөцтэй байх;

5.1.5. дотоод хяналтын болон мэдээллийг хадгалах системтэй байх;

5.1.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системтэй байх;

5.1.7. өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны байх;

5.1.8. Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон бусад шаардлагыг хангасан байх;

5.1.9. хуульд заасан бусад.

5.2. Үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, шийдвэр гаргах түвшний ажилтан дараах шаардлагыг хангасан байх:

5.2.1. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

5.2.2. Эрүүгийн хуулийн Арван наймдугаар бүлэг заасан Эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдоогүй байх;

5.2.3. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь тухайн бизнесийн үйл ажиллагааг удирдахад харшлахгүй байх;

5.2.4. дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын нэг болон хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн байх;

5.2.5.хууль болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон бусад шаардлага.

5.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн хөрөнгөтэй байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ болон түүнд тавигдах нэмэгдэл шаардлагыг Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

5.5.Энэ хуулийн 5.2-т заасан өөрийн хөрөнгөнд гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө хамаарахгүй.

5.6.Иргэн виртуал хөрөнгийн үйлчилгээг үзүүлэхийг хориглоно.

6 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналт тавих

6.1.Энэ хуулийн 4.1.2.а, 4.1.2.б-т заасан виртуал хөрөнгийн үйл ажиллагаа үзүүлэх хүсэлтийг Монголбанк, 4.1.2.в, 4.1.2.г, 4.1.2.д-д заасан виртуал хөрөнгийн үйл ажиллагаа үзүүлэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороо хүлээн авч, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд бүртгэнэ.

6.2.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй этгээдийг Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй.

6.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуулийн 6.1-д заасны дагуу Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлснээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлнэ.

6.4.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн мэдээлэл нийтэд нээлттэй ил тод байна. Бүртгэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ хуулийн 6.1-д заасан байгууллага нь тухай бүр мэдээллийг шинэчилнэ.

6.5.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээр бүртгүүлэхэд дараах этгээд хүсэлт гаргана:

6.5.1.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч;

6.5.2.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага;

6.5.3.хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан;

6.5.4.итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд.

6.6.Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээтэй холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.6.1.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргасан этгээдийг бүртгэх, үйлчилгээ үзүүлэгчийн зохистой засаглал, үйл ажиллагаа, тайлан мэдээнд

тавигдах шаардлага, хяналт шалгалт хийх, хязгаарлалт тогтоохтой холбоотой дүрэм, журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батлах;

6.6.2.энэ хуулийн 4.1.2.а, 4.1.2.б-т заасан виртуал хөрөнгийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг Монголбанк, 4.1.2.в, 4.1.2.г, 4.1.2.д-д заасан виртуал хөрөнгийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хороо хангуулах;

6.6.3.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулах, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

6.6.4.энэ хуулийн 6.2-т заасны дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтийг бүртгэхээс татгалзах;

6.6.5.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

6.6.6.шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагатай хамтран энэ хуулийн 6.6.5-д заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

6.6.7.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, үйл ажиллагааг зогсоож бүртгэлээс хасах.

6.7.Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийхдээ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрх эдэлж, үүрэгийг биелүүлнэ.

6.8.Монголбанкны хянан шалгагч виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийхдээ Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасан бүрэн эрх эдэлж, үүрэгийг биелүүлнэ.

6.9.Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хорооноос нэмэлт шаардлага тавьж болно.

6.10.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн гүйлгээ илгээх, хүлээн авах, харилцагч, харилцагчийн хүрээ хязгаар, гүйлгээ хийгдэх гадаад улс орон, эсхүл тодорхой хуулийн этгээд, гадаад улс орноос хөрөнгө оруулалт татах болон бусад үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоож болно.

6.11.Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхдээ шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэшсэн этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно.

6.12.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хорооноос шаардсан тохиолдолд эдгээр байгууллагын хүлээн зөвшөөрсөн аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр аудит хийлгэх бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

6.13.Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэлээс хасах тохиолдолд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн үйл ажиллагааны төрлийг хасуулах хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

7 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг

7.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаагаа эхлүүлэхийн өмнө энэ хуульд заасан шаардлага болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран гаргасан нэмэлт шаардлагыг бүрэн хангасан байна.

7.2.Виртуал хөрөнгийн үйлчилгээнд дараах зарчмыг баримтална:

7.2.1.хууль дээдлэх, шударга ёсны зарчим;

7.2.2.зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж, удирдлага зохион байгуулалтыг үр дүнтэй явуулах;

7.2.3.өөрийн үйл ажиллагаа болон харилцагчийн эрсдэлийг тодорхойлох, тохирсон эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байх;

7.2.4.энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаар тогтоосон стандарт шаардлагыг хангаж ажиллах.

7.3.Харилцагчийн эрх ашгийг зохих ёсоор хамгаалж, харилцагчтай шударга, ойлгомжтой, төөрөгдөлд оруулахгүйгээр харилцана.

7.4.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчийн тухайн үйлчилгээнд хамаарах виртуал хөрөнгө болон мөнгөн хөрөнгийг гүйлгээ, шилжүүлэг хийхэд бүрэн бэлэн байлгана. Бүрэн бэлэн байлгаж чадаагүйгээс үүдэн гарсан хохирлыг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

7.5.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаандаа энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж ажиллана.

7.6.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуулийн 5.1.3-т заасан этгээд өөрчлөгдөх тохиолдолд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран баталсан журмын дагуу хүсэлт гаргаж, шийдвэрлүүлнэ.

7.7.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, түүний удирдлага, холбогдох этгээд, эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь санхүүгийн тайлан, санхүүгийн анхан шатны баримт, тэдгээрийг нотлох баримт, хууль тогтоомжийн дагуу удирдлагын үйл ажиллагааны талаар бүрдүүлбэл зохих баримт, мэдээ, мэдээлэл болон санхүүгийн үйл

ажиллагаанд хэрэглэж байгаа тоног төхөөрөмж, программ хангамж, тэдгээрийн байршлын талаарх дэлгэрэнгүй жагсаалт, тэдгээрт нэвтрэх нууц түлхүүрийг Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчид саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гарган өгч, хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангана.

7.8.Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо, тэдгээрийн хянан шалгагчийн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шаардсан баримт, мэдээ, мэдээлэл байхгүй бол энэ тухайгаа холбогдох эрх бүхий этгээд тайлбарын хамт албан бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

7.9.Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зогсоож, бүртгэлээс хассан тохиолдолд энэ талаарх мэдээллийг харилцагчдад нэн даруй мэдэгдэнэ.

7.10.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч харилцагчийн хооронд байгуулсан гэрээ хэлцэлд дараах нөхцөлийг заавал тусгана:

7.10.1.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох төлөвлөгөө;

7.10.2.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бүртгэлээс хасагдаж, үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд авах арга хэмжээ;

7.10.3.виртуал хөрөнгө нь хууль ёсны мөнгөн тэмдэгтэд хамаарахгүй, эсхүл Төв банк, эсхүл Засгийн газраас баталгаажуулж, виртуал хөрөнгө нь хадгаламжийн даатгал, үнэт цаасны хөрөнгө оруулагчдыг хамгаалах аливаа даатгалд хамаардаггүй талаарх мэдээлэл;

7.10.4.виртуал хөрөнгийн гүйлгээ нь гүйлгээ хийгдсэн хугацаанаас үл хамааран бүртгэлийн системд бүртгэгдсэн хугацаагаар гүйлгээ хийгдсэнд тооцогдох нөхцөл;

7.10.5.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, харилцагчийн эрх, үүрэг;

7.10.6.харилцагчийн анхны шаардлагаар түүний виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарах мөнгөн хөрөнгийг гаргаж өгөх, эсхүл виртуал хөрөнгийг шилжүүлэх нөхцөл;

7.10.7.виртуал хөрөнгийн талаарх олон улсын хэм хэмжээ, дотоодын хууль тогтоомжоос хамаарч виртуал хөрөнгийн үйлчилгээ болон үнэ цэнэ огцом өөрчлөгдөх эрсдэл;

7.10.8.виртуал хөрөнгийн гүйлгээ нь буцаах боломжгүй, залилан мэхлэх шинжтэй, эсхүл алдаатай гүйлгээнээс үүдэн гарах хохирол, хор уршиг нөхөн төлөгдөхгүй байх эрсдэл;

7.10.9.виртуал хөрөнгийн үнэ цэнэ нь зах зээлд оролцогчдын эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдох тул үнэ цэнийн хэлбэлзлээс хамаарч их хэмжээний алдагдал хүлээх эрсдэл;

7.10.10.виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ нь залилан мэхлэх болон цахим халдлагад өртөх өндөр эрсдэл;

7.10.11.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид технологийн хүндрэл гарсан тохиолдолд харилцагч өөрийн виртуал хөрөнгийг ашиглах, хэрэглэх боломжгүй болох эрсдэл;

7.10.12.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгө нь харилцагчид учирсан хохирлыг бүрэн барагдуулж хүрэлцэхгүй байх эрсдэл.

7.11.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхдээ бусад хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг хамтад нь үзүүлэх тохиолдолд тухайн хуульд заасан зөвшөөрөл авсан байна.

7.12.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийн мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн дансыг тусад нь байршуулж ажиллана.

7.13.Харилцагчийн мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн дансан дахь хөрөнгийг харилцагч, эсхүл харилцагчаас эрх олгосон итгэмжлэл бүхий этгээд захиран зарцуулах эрхтэй.

7.14.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээс бусад зорилгоор харилцагчийн мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн дансан дахь хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно.

8 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, бүртгэлээс хасах

8.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй тохиолдолд үйл ажиллагааны онцлог, зөрчлийн шинж байдлыг харгалзан үйл ажиллагааг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хязгаарлах, зогсоох, эсхүл бүртгэлээс хасна.

9 дүгээр зүйл.Баримтын хадгалалт, хамгаалалт

9.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь тухайн үйл ажиллагааны явцад бий болсон цаасан болон дижитал баримтыг хүлээн авсан, эсхүл уг баримтыг үүсгэсэн өдрөөс хойш холбогдох хуульд заасны дагуу 15-аас доошгүй жил хадгална.

9.2.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаандаа Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан албан хэрэг хөтлөлт болон байгууллагын архивт баримтлах журмыг мөрдөнө.

10 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал

10.1.Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, тэдгээрийн албан тушаалтан, ажилтан энэ хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхдээ олж авсан мэдээллийн нууцлалыг доор дурдсанаас бусад тохиолдолд шууд болон шууд бусаар задруулахыг хориглоно:

10.1.1.энэ хуульд заасан чиг үүргийг гүйцэтгэх;

10.1.2.хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны явцад прокурорын зөвшөөрөлтэй холбогдох байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг гүйцэтгэх;

10.1.3.хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд прокурорын зөвшөөрөл шаардахгүй мэдээллийг хууль сахиулах байгууллагад өгөх;

10.1.4.тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхтэй холбогдох мэдээллийг шалгах;

10.1.5.шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор нотлох баримт, мэдээлэл гаргуулах;

10.1.6.шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

10.1.7.Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргийг биелүүлэх.

11 дүгээр зүйл.Бүртгэлийн үйл ажиллагааны шимтгэл

11.1.Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээр бүртгүүлэх хүсэлт гаргасан этгээдээс бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдуулан шимтгэл авна.

11.2.Энэ хуулийн 4.1.2.а, 4.1.2.б-д заасан виртуал хөрөнгийн үйл ажиллагаа үзүүлэгчийн бүртгэлийн шимтгэлийн хэмжээг Монголбанк, 4.1.2.в, 4.1.2.г, 4.1.2.д-д заасан виртуал хөрөнгийн үйл ажиллагаа үзүүлэгчийн бүртгэлийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу Засгийн газар тус тус батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД

12 дугаар зүйл.Хамтын ажиллагаа

12.1.Виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналт тавих, шалгалт хийх эрх бүхий байгууллага нь эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах хүрээнд төрийн байгууллага, хувь хүн, хуулийн этгээд, гадаад улсын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар адил түвшний байгууллага болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллаж болно.

13 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

13.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.2.Энэ хууль, хууль тогтоомж зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангаагүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол үүссэн нөхцөл байдал, дутагдлыг харгалзан Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо, тэдгээрийн хянан шалгагч дараах арга хэмжээг авна:

13.2.1.дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

13.2.2.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулах, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

13.2.3.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох;

13.2.4.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хязгаарлах;

13.2.5.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой үйл ажиллагааг зогсоож, бүртгэлээс хасах.

13.3.Эрх бүхий албан тушаалтнаас энэ хуулийн 13.2-т заасны дагуу өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, сануулга, шаардлагыг биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасан шийтгэлийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

13.5.Хуульд өөрөөр заагаагүй бол Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль тогтоомж зөрчсөнөөс учирсан хохирлыг Иргэний хуульд заасны дагуу нөхөн төлүүлнэ.

14 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

14.1.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг